



## НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 8/67

Улаанбаатар хот

### Г Ажлын хэсэг томилох тухай Г

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30.2, 30.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, нийслэлийн Онцгой байдлын газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.2.17-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Онцгой байдлын газрын харьяа бүтцийн нэгжүүдийн өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд хэлтэс, анги, салбаруудын ажлын байрны тохижилт, засвар үйлчилгээ, автомашин, техник, тоног төхөөрөмжийн бэлтгэл бэлэн байдалд хийх шалгалтыг 2019 оны 09 дүгээр сарын 16, 17-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг шалгах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шалгалтын удирдамжийг хоёрдугаар, шалгалтын хуваарийг гуравдугаар, шаардагдах зардлын тооцоог дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Шалгалт явуулахад шаардагдах зардалд 165.600 (нэг зуун жаран таван мянга зургаан зуун) төгрөгийг зохих зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт явуулсан тухай дүнг 2019 оны 09 дүгээр сарын 19-ний дотор танилцуулахыг Тэргүүн дэд дарга (дэд хурандаа Н.Нямхорлоо)-д үүрэг болгосугай.



Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын  
2019 оны 09 дүээр сарын ~~ж~~-ны өдрийн  
~~Аж~~дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

1117155601  
УХА0038 9077073

## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Урантулга Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга, дэд хурандаа,

Гишүүд:

А.Чинбат Хангарт үйлчилгээ, орон сууц, байрны ашиглалт хариуцсан  
мэргэжилтэн, дэд хурандаа,

Г.Амгалан Нягтлан бодогч, дэслэгч,

Нарийн бичиг:

Б.Сэргамба Техник, тоног төхөөрөмж хариуцсан инженер, ахмад,

Жолооч:

Жолооч, холбоочин

---оОо---

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын  
2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн  
167 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт  
УХАД038 9077073

## БҮТЦИЙН НЭГЖҮҮДИЙН 2019-2020 ОНЫ ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ШАЛГАХ УДИРДАМЖ

Нэг: Удирдамжийн зорилго:

Гамшгаас хамгаалах тухай болон Галын аюулгүй байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын дүрэм, журмын хүрээнд харьяа бүтцийн нэгжүүдийн автомашин, техник, тоног төхөөрөмжийн бэлтгэл бэлэн байдал, хэлтэс, анги, салбаруудын ажлын байрны тохижилт засвар, үйлчилгээ хийсэн байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, хяналт шалгалт явуулах 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулахад оршино.

Хоёр: Шалгах ажлын чиглэл

Нийслэлийн Онцгой байдлын газрын харьяа нийслэлийн Аврах анги-105, Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төв, дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Гал түймэр унтраах, аврах ангиудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахтай холбогдуулан барилга, байгууламж, автомашин техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээ хийсэн байдалтай газар дээр нь танилцаж, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөний хэрэгжилт, хийж гүйцэтгэсэн ажилд үнэлэлт, дүгнэлт өгөх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөхөд чиглэгдэнэ.

Гурав: Хамрах хүрээ, шалгах үзүүлэлт, хугацаа

Нийслэлийн Онцгой байдлын газрын харьяа нийслэлийн Аврах анги-105, Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төв, 9 дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Гал түймэр унтраах, аврах 15 ангиуд хамрагдана.

Удирдамжийн хүрээнд шалгалтыг 2019 оны 09 дүгээр сарын 16, 17-ний өдрүүдэд бүтцийн нэгжүүд дээр хуваарийн дагуу зохион байгуулна.

Шалгалтыг тогтоосон хугацаанд явуулж дууссанаас хойш 3 хоногийн дотор дүнг нэгтгэн газрын удирдлагад танилцуулна.

Дөрөв: Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөний дагуу шалгах чиглэл:

Нийслэлийн Онцгой байдлын газрын харьяа нийслэлийн Аврах анги-105, Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төв, дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Гал түймэр унтраах, аврах ангиудад удирдамжийн дагуу дараах ажлыг зохион байгуулна.

Үүнд:

А. Засвар, тохижилт, бүтээн байгуулалт,  
барилга, байгууламжын талаар

1. Барилга, байгууламжийн паспортжуулалт, цахим хэлбэрт оруулж, энэ онд хийгдсэн засвар, тохижилтын ажлын тухай тайлан, баяжилт хийгдсэн эсэх, /барилгын паспорт болон цахим файлд баяжилт хийгдсэн байдал/ хувийн хэрэг шинээр нээсэн эсэх, барилга, байгууламжийн өмчлөгчийн тухай мэдээлэл зэргийг бүрдүүлсэн эсэх.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээ, газар эзэмших гэрээ, кадастрын зураг, Google map-аас татсан газрын зураг /өнгөт/, газрын төлбөр төлсөн баримт байгаа эсэх.

3. Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 2019 онд хийгдсэн Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт, тайлан, "Бүтээлч ажлын тайлан" /зурган болон бичгэн хэлбэр/-ээр бэлтгэсэн байдал, барилга, байгууламжийн өрөө, тасалгаанд хийгдсэн засвар, гадна талбайн тохижилт.

5. Барилга, байгууламжийн цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус, хог тээвэрлэлтийн гэрээний хугацааг сунгасан эсэх.

6. Алба хаагчдын хувцас хангарт, хувцасны хэмжээ, эдэлгээний хугацаа тусгагдсан "Хувцас хангалтын нэгдсэн цахим сан" бүрдүүлсэн эсэх, 2019 онд хангальтаар авсан хувцас, хэрэгслийн судалгаа, хугацаа дууссан хувцас болон шинээр томилогдсон алба хаагчдад нөхөн хангальтаар авах шаардлагатай хувцасны судалгааг гаргасан эсэх.

7. Алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, дэмжлэг туслалцаа үзүүлсэн эсэх, гэр хороололд амьдардаг алба хаагчдад тулээ, нүүрс хөнгөлөлттэй үнээр олгуулах талаар хийж хэрэгжүүлсэн ажил.

8. Халаалт /уурын зуух/ авахад бэлтгэсэн байдал, шүүлтүүр тавьсан эсэх, хийгдсэн засвар үйлчилгээ, ангийн гадна дотор цэвэрлэгээ, тохижилт хийгдсэн байдал.

9. Агуулах, багны өрөөний эмх, цэгц, агуулахын бүртгэл хөтлөлт, бараа материалыг хураасан байдал.

Б. Автомашин техник, тоног төхөөрөмжийн  
бэлтгэл бэлэн байдлын талаар

1. Шинээр олгогдсон техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг аюулгүй ажиллуулах, засвар үйлчилгээ хийх, дадлага олгох чиглэлээр сургалт зохион явуулсан байдал.
2. Техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлэх талаар засвар үйлчилгээ хийх, бичиг баримтын бүрдэл, паспорт хөтлөлтийг бүрдүүлсэн байдал, агуулахын эмх, цэгц.
3. Хорт хий утаанаас хамгаалах багны хувийн хэрэг хөтлөлт, цэвэрлэгээ ариутгал, хадгалалт, тээвэрлэлт, хэвийн ажиллагааг хангасан байдал.
4. Намрын хуурайшилтын улирал эхэлж ой, хээрийн гал түймэр гарах эрсдэл нэмэгдэж байгаатай холбогдуулан алба хаагчдын хувийн бэлтгэлийг сайжруулах, ой, хээрийн түймэр унтраах зориулалтын техник, багаж хэрэгслийн аюулгүй ажиллагааг хангах, засвар үйлчилгээг хийж шаардлагатай сэлбэг, хэрэгсэл, шатахууныг нөөцөлж албаны бэлтгэл бэлэн байдлыг хангасан байдал.
5. Техник, тоног төхөөрөмж, авто тавиулан, автомашины дулаалга, дулаалгын материал бэлтгэсэн байдал, дугуй хангалт, аккумуляторын дулаалга хийсэн байдал.
6. 2019-2020 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар авсан техник, багаж хэрэгслийг эд хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн байдал.
7. Автомашин техникийн засвар үйлчилгээ TY-1, TY-2 хийсэн эсэх, шинээр хийж хэрэгжүүлсэн ажил үйлчилгээ.

Дөрөв: Дүн танилцуулах

Нэгдсэн удирдамжийн дүнг тооцож, ололт амжилт, зөрчил дутагдал, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж, Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын зөвлөлд танилцуулна.



Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын  
2019 оны 09 дүгээр сарын 12 -ны өдрийн  
12 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

1117155601  
UXA0038 9077073

**БҮТЦИЙН НЭГЖҮҮДИЙН 2019-2020 ОНЫ ӨВӨЛЖИЛТИЙН  
БЭЛТГЭЛ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ШАЛГАХ ХУВААРЬ**

дд/д	Хэлтэс, анги байгуулага	Шалгалт явуулах өдөр
11	Нийслэлийн Аврах анги-105	2019-09-16
33	Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төв	2019-09-16
44	ХУД-ийн ОБХ-ийн ГТУА-65 дугаар анги	2019-09-16
55	ХУД-ийн ОБХ-ийн ГТУА-30 дугаар анги	2019-09-16
66	ХУД-ийн ОБХ-ийн ГТУА-14 дүгээр анги	2019-09-16
77	БГД-ийн ОБХ-ийн ГТУА-18 дугаар анги	2019-09-16
88	СХД-ийн ОБХ-ийн ГТУА-11 дүгээр анги	2019-09-16
99	СХД-ийн ОБХ-ийн ГУТА-29 дүгээр анги	2019-09-16
110	СХД-ийн ОБХ-ийн ГУТА-26 дугаар анги	2019-09-16
111	ЧД-ийн ОБХ-ийн ГТУА-10 дугаар анги	2019-09-17
112	БЗД-ийн ОБХ-ийн ГТУА-35 дугаар анги	2019-09-17
113	БЗД-ийн ОБХ-ийн ГТУА-63 дугаар анги	2019-09-17
114	СБД-ийн ОБХ-ийн ГТУА-34 дүгээр анги	2019-09-17
15	СБД-ийн ОБХ-ийн ГТУА-74 дүгээр анги	2019-09-17
6	БНД-ийн ОБХ-ийн ГТУА-64 дүгээр анги	2019-09-17
117	НД-ийн ОБХ-ийн ГТУА-28 дугаар анги	2019-09-17
18	БХД-ийн ОБХ-ийн ГТУА-80 дугаар анги	2019-09-17
	НИЙТ	